

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД, ДҮНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН
2023 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2023 оны 12 дугаар сарын 05

Мандалговь хот

№	2	Зарцуулсан төсөв	4	Хувь
1	"Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай" Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 01/01 дүгээр зөвлөмж, Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам", Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 75 дугаар зүйлийг чанд мөрдөж ажиллах.	3	Энэ онд гадаад хамтын ажиллагааны хоёр улсын хоёр муж, нэг хотод ажиллаж гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр ажилласан болно. Мөн Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргааны Холбоо(NEAR)-ийн Бүгд Хуралд ороцов. Гадаадын муж, хотуудад ажиллахдаа "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам", Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 75 дугаар зүйлийг чанд мөрдөж ажиллаж удирдамжийн төсөл боловсруулсан Засгийн газрын Хэрэг эрхлэх газраар батлуулан, тайлан, мэдээг хүргүүлсэн.	5
2	Гадаадад айлчлах, албан хэргээр зорчих, олон улсын арга хэмжээнд оролцох, албан ёсны яриа хэлэлцээр явуулахдаа 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийг чанд мөрдөн ажиллах, түүнчлэн удирдамжийн төсөл(удирдамжид айлчлалын ач холбогдлыг тусгасан байх), зардлын төсөв боловсруулан дээд шатны байгууллагад арга хэмжээ болохоос 10-аас доошгүй өдрийн өмнө ирүүлж санал авч байх.	-	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанси муж, ӨМӨЗО-ны Баяннуур хот, Бүгд Найрамдах Солонгос Улсын муж хотуудад ажиллах гурван удирдамжийн төслийг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газраар батлуулан, Зардлын төсвийг боловсруулан батлуулаагүй болно.	100
3	Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор баталсан "Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам"-ыг чанд мөрдөх, ингэхдээ өөрийн эрх хэмжээний асуудлаар гадаад улсын адил түвшний байгууллага, эсхүл олон улсын байгууллагатай гэрээ байгуулах тохиолдолд гэрээ байгуулахаас 10 хоногийн өмнө уг гэрээний төслийг дээд шатны байгууллагад хүргүүлж зөвшөөрөл авах.	-	Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор баталсан "Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам"-д заасны дагуу гадаад улсын адил түвшний байгууллагатай гэрээ байгуулах нөхцөл үүсээгүй тул энэ онд гэрээ байгуулаагүй.	100
4	Гадаад улсын орон нутагтай хөгжүүлж буй харилцааны эрчийг хадгалах, хамтын ажиллагааны баримт бичгийн хэрэгжилтийг хангах.	ОНТ 98,692.3	Гадаад улсын орон нутгуудтай байгуулсан хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор хамтын ажиллагааны баримт бичиг байгуулсан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанси муж, ӨМӨЗО-ны Баяннуур хот, Бүгд Найрамдах Солонгос Улсын Гүяан хотод нийт гурван удаагийн айлчлал зохион байгуулсан.	100

	<p>Айлчлалын үр дүнд хамтын ажиллагааны баримт бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд хөдөө аж ахуйн салбарын туршлага судалсан. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Баяннуур хотод хийсэн айлчлалын үеэр эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд Баяннуур хотын Анагаах ухааны эмнэлгийн үйл ажиллагаатай танилцан, уламжлалт анагаах ухааны эмчилгээ, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, шинжлэх ухааны судалгаа, сургалт, эрүүл мэндийг сахин хамгаалах, бэлтгэх үйл ажиллагаатай танилцсан бөгөөд Баяннуур хотын эмч нарын эрүүл мэндийн үзлэг оношилгоог хамтран зохион байгуулахаар ярилцав. Хөдөө аж ахуйн салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд ингэн сүүний ферм байгуулах, хүлэмжийн ногооны аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр туршлага судлан 2024 оноос хамтран ажиллахаар хэлэлцэв. Баримт бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулав. Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнги аймгийн Гуван хоттой хамтын ажиллагааны баримт бичигт тусгасан Хүүхэд, залуучуудын солилцооны хөтөлбөрийг зохион байгуулах заалтын хүрээнд төрийн албанд дадлагажих 6 сарын хөтөлбөрт нэг албан хаагчийг хамруулав.</p> <p>Япон Улсын Эхиме мужийн Сейёо хотын даргын Дундговь аймагт айлчлах ажлыг зохион байгуулж, Дундговь аймаг, Сейёо хотын Найрамдлын төлгийг байгуулав. Мөн айлчлалын үр дүнд соёлын хамтын ажиллагааг өргөжүүлэн үндэсний урлаг, соёлыг сурталчлах тоглолтыг 2024 онд Сейёо хотод зохион байгуулахаар тохиролцов. Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбоо (NEAR)-ийн гишүүн байгууллагын хүрээнд тус байгууллагын 52 гишүүн орон нутгийн 62 өндөр дээд түвшний албан тушаалтан оролцсон 14 дүгээр Бүгд Хуралд аймгийн Засаг дарга оролцов. Мөн Зүүн хойд Азийн таван улсын (БНХАУ, Япон, БНСУ, Монгол, ОХУ) орон нутгуудын нийт 80 гаруй төрийн албан хаагчдыг хамруулсан "NEAR - Гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал 2023 -т аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн оролцов. Мөн Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбооны Байгаль орчин хамгааллын дэд хорооноос Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Зүүн Хойд Азийн байгаль орчин хамгааллын үйл ажиллагаанд залуу манлайлагчдыг хөгжүүлэх нь" сэдэвт олон улсын форумыг зохион байгуулж Дундговь аймгийн сурэгчид оролцов.</p>
--	--

5	Гадаад улсын төрийн байгууллага болон аж ахуй нэгж, олон улсын байгууллагын төлөөлөлтэй уулзахдаа Монгол Улсын гадаад бодлогын байр суурийн хүрээнд ярилцах, ярианы сэдвийг урьдчилан боловсруулж дээд шатны байгууллагаас санал авах.	-	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанси муж, Баяннуур хот, Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнги аймгийн Гуян хот, Жолланам аймагт ажиллахдаа Гадаад харилцааны яамнаас санал авч удирдамжийн төсөл боловсруулан ажилласан.	100
6	Хувийн хэргээр гадаад улсад зорчихдоо албан ёсны уулзалт, яриа хэлэлцээ хийх, гэрээ байгуулах, ёслолын арга хэмжээнд оролцохгүй байх.	-	Хувийн хэргээр гадаад улсад зорчихдоо албан ёсны уулзалт, яриа хэлэлцээ хийх, гэрээ байгуулах, ёслолын арга хэмжээнд оролцоогүй болно.	100
7	Гадаад улсад албан ёсны, эсхүл ажлын айлчлал хийсэн, албан хэргээр зорчсон, олон улсын арга хэмжээнд оролцсон, албан ёсны яриа хэлэлцээ явуулсан тухай илтгэх хуудасны хувийг ажлын 7 хоногийн дотор дээд шатны байгууллагад хүргүүлэх.	-	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанси муж, Өвөр Монголын Өөртөө Засах Орны Баяннуур хот, Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнги аймгийн Гуян хот, Жолланам аймагт ажилласан тайлан, мөн Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбоо(NEAR)-ны Бүгд Хуралд оролцсон тухай нийт гурван тайланг Засгийн газрын Хэрэг Эрхлэх газар, Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.	100
8	2023 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөг 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэх.	-	Сүмд, агентлаг, хэлтсийн гадаад арга хэмжээний төлөвлөгөөг нэгтгэн 2 зорилт, 14 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. Хэрэгжилтийг нэгтгэж байна. 12 сарын 15-ны дотор Гадаад харилцааны яаманд хүргүүлнэ.	100
9	Монгол Улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам"-д заасан албан паспорт эзэмших эрхтэй этгээдэд албан паспорт мэдүүлэх.	-	Журмын хүрээнд 15 албан тушаалтанд албан паспорт мэдүүлсэн.	100
10	"Монгол Улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам"-ыг чанд мөрдөх, хяналт тавих, тайлан, мэдээллийг 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэх.	-	Дипломат, албан гадаад паспорт эзэмшигчдийн мэдээллийг сүмд, агентлагаас авч нэгтгэн Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.	100
11	Гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар болон Олон улсын байгууллагуудад орон нутгийг танилцуулах сурталчилгаа, соёлын арга хэмжээ зохион байгуулахад Гадаад харилцааны яамтай хамтран ажиллах.	100 хувь -10	Энэ онд гадаад улсаас Монгол улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар болон Олон улсын байгууллагуудад орон нутгийг танилцуулах арга хэмжээ зохион байгуулагдаагүй.	-

БАТАЛГААЖУУЛСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ



ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ХАДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА
Н. ТҮВШИНЖАРГАЛ

НЭГТГЭСЭН:
ГАДААД ХАРИЛЦААНЫ АЖИЛТАН *tg28a* Б. АДЬЯА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Эж* Э. ОДОНЧИМЭГ

Дундговь аймгийн Засаг даргын Гадаад харилцааны сайдтай 2023 онд хамтран
ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн
ажлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 06

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Гадаад харилцааны сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран
ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны
гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, үйл ажиллагааны
төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг сайжруулж, цаашид гарах үр дүн, үр нөлөөг
нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Гадаад харилцааны сайдтай байгуулсан аймгийн Засаг даргын хамтран
ажиллах гэрээний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ,
үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын
баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр
Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-
шинжилгээ, үнэлгээ хийлээ.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 11 үүргийг хүлээж, үүргийг
орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган үр дүнг тооцож ажилласнаар хагас бүтэн
жилээр арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай байна. Нийт 11 арга хэмжээг
төлөвлөн хэрэгжүүлэхээс “Гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат
төлөөлөгчийн газар болон Олон улсын байгууллагуудад орон нутгийг танилцуулах
сурталчилгаа, соёлын арга хэмжээ зохион байгуулахад Гадаад харилцааны яамтай
хамтран ажиллах” гэсэн арга хэмжээний хүрээнд энэ онд гадаад улсаас Монгол
улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар болон Олон улсын байгууллагуудад
орон нутгийг танилцуулах арга хэмжээ зохион байгуулагдаагүй нь орон нутгаас
шалтгаалсан зүйлгүй тул үнэлгээнээс хасаж тооцлоо.

ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хамтын ажиллагаатай гурван муж, хот болох Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанси муж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Баяннуур хот, Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнги аймгийн Гуяан хотод хамтын ажиллагааны эрчийг хадгалах, харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх зорилгоор айлчлал хийн, Япон Улсын Эхиме мужийн Сейёо хотын Дарга тэргүүтэй төлөөлөгчдийг орон нутагтаа хүлээн авч уулзах айлчлалыг зохион байгуулав.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанси мужид хийсэн айлчлалын үеэр хамтын ажиллагааны баримт бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор аялал жуулчлалын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал солилцов.



Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Баяннуур хоттой 2024 оноос эхлэн ингэн сүүний ферм байгуулах, уламжлалт анагаах ухааны хамтарсан үзлэг зохион байгуулах зэрэг ажлыг зохион байгуулахаар хэлэлцэв.



Бүгд Найрамдах Солонгос Улстай хамтын ажиллагааны баримт бичигт тусгагдсан залуучуудын солилцоог идэвхжүүлэх заалтын хүрээнд төрийн албан хаагчийг дадлагажих хөтөлбөрт хамруулав. Мөн төрийн бус байгууллагын хамтын

ажиллагааг өргөжүүлэн Дэлгэрцогт суманд Гуяан хотын Дахам төрийн бус байгууллагатай хамтарсан эрүүл мэндийн үзлэг зохион байгуулав.

Япон Улсын Эхиме мужтай цөлжилт, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтын ажиллагааг эхлүүлэн Дундговь аймаг, Сейёо хотын Найрамдлын төгөлийг Мандалговь хотод байгуулав.

Мөн 2024 оноос хоёр орны уламжлал, соёлыг сурталчлах урлагийн арга хэмжээг зохион байгуулахаар харилцан тохиролцов.



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний Гадаад харилцааны салбарын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 100 хувь буюу “Үр дүнтэй” хэрэгжсэн гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн 3 муж, хотын албан ёсны айлчлалын удирдамжийг тухай бүр нь боловсруулан Гадаад харилцааны яамнаас санал аван Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зөвшөөрөл авч ажиллаж, айлчлалын үр дүнгийн талаар дээд шатны байгууллагад хугацаанд нь тайлагнах ажлыг хууль, журмын дагуу хэрэгжүүлж, тогтвортой нэгдмэл гадаад бодлогын хүрээнд гадаад хамтын ажиллагааг идэвхтэй явуулж байгаа нь сайшаалтай байна.

Гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд 98.3 сая төгрөгийг гадаад хамтын ажиллагааны тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээнд зарцуулсан байна.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн уулзалт, арга хэмжээний харьцуулалт/2022-2023/

Сайр	2022 он уулзалт				2023 он уулзалт				2022 он арга хэмжээ				2023 он арга хэмжээ			
	0	0	1	0	1	1	1	1	0	1	0	0	0	1	2	1
■ Баяннуур	0	0	1	0	1	1	1	1	0	1	0	0	0	1	2	1
■ Шанси	0	0	1	0	1	1	1	1	0	1	0	0	0	1	2	1
■ Гуяан	1	0	0	0	1	1	1	1	0	1	0	0	0	1	2	1
■ Сейёо	0	0	1	0	1	1	1	1	0	1	0	0	0	1	2	1

Дээрх график болон арга хэмжээний хэрэгжилтийн тайлангаас харахад 2023 онд зохион байгуулсан уулзалт, арга хэмжээний тоо өссөн байгаа нь гадаад хамтын ажиллагааны баримт бичигт тусгагдсан арга хэмжээнүүдийг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна гэж дүгнэж байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Төрийн захиргааны удирдлагын хэлтэст:

1.Гэрээнд тусгагдсан үүргийн хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө суурь түвшин, хүрэх түвшин бодитой судалгаанд үндэслэн тодорхойлох

2.Тайланг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу хүрэх түвшинд хүрсэн эсэхийг тайлагнахаас гадна үр дүн, үр нөлөөний талаар тайлагнаж хэвших мөн нотлох баримтыг тайланд хавсаргаж байх

Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Одончимэг